



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Газрын дарга: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 260512
Цахим хаяг:
oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Гэрэл
Утас: 263813
Цахим хаяг:
gerelts@audit.gov.mn

Монгол Улсын
Үндэсний аудитын газар
Улаанбаатар
Бага тойруу
Засгийн газрын IY байр
Цахим хуудас: www.audit.mn

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс,
гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

Хавсралт 4: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн
тайлан

Оршил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын (ЗГХЭГ) даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаархи зөвлөмжийг тусгасан болно.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан.

Ийнхүү хянахдаа байгууллагын дотоод хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархи өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудал хөндөгдсөн бөгөөд тэдгээрийг ЗГХЭГ-ын удирдлагын анхааралд хандуулж байна.

ЗГХЭГ-ын даргын төсвийн багцад 2013 онд 27.0 тэрбум төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 22.8 тэрбум төгрөг буюу батлагдсан төсвийн 84.4 хувийг зарцуулсан байна.

Төсвийн багцад хамаарах 21 шууд захирагчаас аудитад хамрагдсан 19, үүнээс дүгнэлт гарсан 11, түүвэрт хамрагдсан 8 байна.

Гарсан дүгнэлтүүд бүгд “зөрчилгүй” байгаа нь өмнөх оноос дүгнэлтийн хэлбэрийн хувьд ахиц гарсан харагдаж байна.

Нийт зардлын 66.5 хувийг УАГ, 0.6 хувийг аймаг, нийслэлийн аудитын газар, 32.0 хувийг гэрээт аудитын компаниуд шалгаж, 0.9 хувь нь аудитад хамрагдаагүй байна.

ЗГХЭГ-ын даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг байгууллага бүрээр харуулбал,

1.Удирдлагын академи:

Удирдлагын академийн 2013 оны санхүүгийн тайланд “Улаанбаатар-Аудит корпораци” ХХК аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна. 2013 онд тус байгууллага улсын төсвөөс 1,021.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,590.9 сая, туслах үйл ажиллагаанаас 173.4 сая, Сургалтын төрийн сангаас 517.7 сая, нийт 4,303.9 сая төгрөгийн орлого, санхүүжилттэй, 2,853.8 сая төгрөгийн зардалтай ажилласан байна.

Аудитаар 19.2 сая төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, 207.3 сая төгрөгийн сургалтын төлбөрийн орлогыг авлагаар бүртгээгүй зэрэг зөрчил илэрсэнд холбогдох зөвлөмж өгсөн байна.

2.Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа УТҮГ:

Засгийн газрын байруудын нэгдсэн захиргаа УТҮГ-ын 2013 оны санхүүгийн тайланд “Өлзийт экаунт аудит” ХХК аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.

Аудитаар УСНББОУС болон НББОУС , Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журамд нийцүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх зөвлөмж өгсөн байна.

3.Монгол төрийн түүхийн музей:

Монгол төрийн түүхийн музейн 2013 оны санхүүгийн тайланд “Санхүүч-Аудит” ХХК аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт гаргасан байна. Тоног төхөөрөмж нийлүүлэхээр 2007 онд байгуулсан гэрээний хэрэгжилтээс үүссэн 6.2 сая төгрөгийн авлагыг өнөө хүртэл барагдуулаагүй зөрчил илэрсэн байна.

4. Төр засгийн амралт, үйлчилгээний цогцолбор ТӨҮГ:

Төр засгийн амралт, үйлчилгээний цогцолбор ТӨҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК гүйцэтгэж, “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна. 2013 оны 10 дугаар сард хийсэн явцын аудитаар 8 асуудлаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, жилийн эцэст нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хуулийн дагуу архивлах талаар зөвлөмж өгсөн байна.

Төр засгийн амралт, үйлчилгээний цогцолбор ТӨҮГ төсвөөс санхүүжилт авдаггүй, бүрэн аж ахуйн тооцоон дээр ажиллаж, 2,175.6 сая төгрөгийн орлого олж, 2,123.9 сая төгрөгийн зардалтай, 51.7 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

5.“Засгийн газрын авто бааз” УТҮГГазар:

Засгийн газрын авто баазын 2013 оны санхүүгийн тайланд “Бисофт-Аудит” ХХК аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт гаргасан байна. Аудитаар Тээврийн хөлсний тарифыг оновчтой уян хатан болгож, зах зээлийн зарчимд нийцүүлэн шилжүүлэх, автомашины сул зогсолт, хүлээлгийн цагийг багасгаж, үр ашигтай тээвэр зохицуулалт хийх, үндсэн бус үйл ажиллагааны орлого нэмэгдүүлэх, жолооч засварчдын цалинг хийснээр олгох системд шилжих, бензиний үнийг талоноор олгох, балансаас балансад шилжиж ирсэн автомашины анхны үнэ болон элэгдлийг бүртгэлд зөв тусгах зөвлөмж өгсөн байна.

Тус бааз төсвөөс зөвхөн цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардалд 2,856.9 төгрөгийн төсөв батлагдаж, 2,253.3 сая төгрөг авсан байна.

Дээрх төсвийн санхүүжилтээс гадна 1,857.2 сая төгрөгийн өөрийн орлого олсноор, нийт 4,110.4 сая төгрөгийн орлого, 4,088.5 сая төгрөгийн зардалтай, 21.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

6. Засгийн газрын хэвлэх үйлдвэр:

Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн 2013 оны санхүүгийн тайланд “Мишээл-Од Аудит” ХХК аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт өгчээ. Аудитаар Санхүүгийн байдлын болон Өмчийн өөрчлөлтийн тайланд 319.1 сая, Мөнгөн гүйлгээний тайланд 23.8 сая төгрөгийн залруулга хийж, цаашид Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн байна.

7. Төр засгийн үйлчилгээ эрхлэх газар:

Төр засгийн үйлчилгээ эрхлэх газарт ҮАГ-аас аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт гаргалаа. Төрийн ордны бэлтгэл дизель станцын үйлчилгээний ажилчдын 2014 оны эхний 1-3 сарын цалинд 11.2 сая төгрөг урьдчилан төлж, шууд зардалд бичсэн, 1999-2008 онд үүссэн нийт 42.8 сая төгрөгийн авлага барагдуулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, Мон Хорус Интернэшнл ХХК-д бэлтгэл дизель станцын үлдэгдэл төлбөрт 12.0 сая төгрөг төлсөн байна. Энэ нь тайлан балансад өглөгөөр тусгагдаагүй явж ирсэн бөгөөд шууд зардалд бичсэн нь тайлант оны үр дүнг бууруулсан байна.

8. Усны үндэсний хорооны ажлын алба:

Усны үндэсний хорооны ажлын албаны 2013 оны санхүүгийн тайланд тусгагдсан зарим гүйлгээг ҮАГ-аас түүвэрт хамруулан шалгахад зөрчил илэрсэнгүй. Тус алба 124.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 121.9 сая төгрөгийн санхүүжилт авч бүрэн зарцуулсан байна. Үүнээс гадна Байгаль хамгаалах сангаас 37.1, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 8.6, ЮНЕСКО-гоос 39.9, Германы Фраунхофын институтээс 14.3 сая төгрөгийн санхүүжилт авч холбогдох төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж, тайлагнасан байна.

9. Газрын шинэтгэлийн үндэсний хорооны ажлын алба:

Газрын шинэтгэлийн үндэсний хорооны ажлын албаны 2013 оны санхүүгийн тайланд тусгагдсан зарим гүйлгээг ҮАГ-аас түүвэрт хамруулан шалгахад зөрчил илэрсэнгүй. Тус алба 2013 онд төсвөөс батлагдсан 70.6 сая төгрөгөөс 65.9 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

10. Улаанбаатар бүсийн зөвлөл:

Улаанбаатар бүсийн зөвлөлийн 2013 оны санхүүгийн тайланд тусгагдсан зарим гүйлгээг ҮАГ-аас түүвэрчлэн шалгалаа. Тус зөвлөл улсын төсвөөс 23.4 сая, нийслэлийн төсвөөс 27.4 сая төгрөгийн санхүүжилт, урьд оны төсвийн хэмнэлтийн орлого 4.4 сая, нийт 55.2 сая төгрөгийн орлого, санхүүжилттэй, 41.3 сая төгрөгийн зарцуулалт ажиллаж, оны эцэст 13.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Хэвлэл захиалгын зардал зүйл ангиараа хэтрээгүй боловч Гранд, Соронз сэтгүүл, Гитар тоглож сурах хичээл, 9-13 насны хүүхдийн англи хэлний хичээл гэх мэт албан ажилд шаардлагатай бус ном, хэвлэлд 48.0 мянган төгрөг зарцуулсныг давтахгүй байхыг анхааруулав.

11.Төвийн бүсийн зөвлөл:

Төвийн бүсийн зөвлөлийн 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төв аймгийн аудитын газар аудит хийж зөрчилгүй санал, дүгнэлт гаргасан байна. Тус зөвлөл 2013 онд 31.9 сая төгрөгийн төсөв батлагдсан, гүйцэтгэлээр 27.7 сая төгрөг зарцуулсан байна.

12. Хангайн бүсийн зөвлөл:

Хангайн бүсийн зөвлөлийн 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Өвөрхангай аймгийн аудитын газар аудит хийж зөрчилгүй санал, дүгнэлт гаргасан байна. Тус зөвлөл 2013 онд 34.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 29.8 сая төгрөг зарцуулсан байна.

13.Баруун бүсийн зөвлөл:

Баруун бүсийн зөвлөлийн 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Ховд аймгийн аудитын газар аудит хийж зөрчилгүй санал, дүгнэлт гаргасан байна. Тус зөвлөл 2013 онд зарцуулахаар баталсан 35.8 сая төгрөгийн төсвөөс 35.8 сая төгрөг зарцуулсан байна.

14.Зүүн бүсийн зөвлөл:

Зүүн бүсийн зөвлөлийн 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Дорнод аймгийн аудитын газар аудит хийж зөрчилгүй санал, дүгнэлт гаргасан байна. Тус зөвлөл 2013 онд 29.9 сая төгрөгийн төсөв батлагдсан, 25.9 сая төгрөг зарцуулсан байна.

15. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын аппарат:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2013 оны санхүүгийн тайланд тусгагдсан зарим гүйлгээг YAГ-аас түүвэрчлэн шалгахад зөрчил илрээгүй бөгөөд тус газар 2,717.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, 2,618.8 сая төгрөг зарцуулсан байна.

16.Ерөнхий сайдын ажлын алба:

Ерөнхий сайдын ажлын албаны 2013 оны санхүүгийн тайланд тусгагдсан зарим гүйлгээг YAГ-аас түүвэрчлэн шалгалаа. Тус ажлын алба 2013 онд 1,323.8 сая төгрөгийн төсөв батлагдаж, 1,246.3 сая төгрөг зарцуулсан байна.

17.Шадар сайдын ажлын алба:

Шадар сайдын ажлын албаны 2013 оны санхүүгийн тайланд тусгагдсан зарим гүйлгээг YAГ-аас түүвэрчлэн шалгалаа. Тус ажлын алба 2013 онд 208.0 сая төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 199.2 сая төгрөг зарцуулсан байна.

18.Замын-Үүд дэхь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын алба:

Замын-Үүд дэхь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын алба 2013 онд 91.9 сая төгрөг батлагдсанаас 82.7 сая төгрөг зарцуулсан байна.

19.Өмнөговь аймаг дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын алба:

Өмнөговь аймаг дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн ажлын алба 2013 онд 152.3 сая төгрөг батлагдсанаас 140.0 сая төгрөг зарцуулсан байна.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд:

ТЗҮЭГ-ын санхүүгийн тайланд 1999-2008 онд үүссэн нийт 42.8 сая төгрөгийн, Удирдлагын академид 19.2 сая, Монгол төрийн түүхийн музейд 2007 онд үүссэн 6.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

ЗГХЭГ-т 2012 онд үүссэн Төрийн ёслол, хүндэтгэлийн өргөө цогцолборт дууны төхөөрөмж, дагалдах хэрэгслийн хамт нийлүүлэх 74.8 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр хаагдаагүй байна.

Тус сайдын төсвийн багцад батлагдан 2011-2013 онд баригдаж эхэлсэн Булган аймгийн ЗДТГ-ын барилгын санхүүжилтэд 2,291.1 сая төгрөг, Засгийн газрын авто баазын барилгын санхүүжилтэд 2,750.0 сая төгрөг, нийт 5,041.1 сая төгрөгийн санхүүжилтийн дүнгээр тухайн байгууллагуудын санхүүгийн тайланд “Дуусаагүй барилга” хэлбэрээр тусгагдаагүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ҮАГ-аас аудит хийж санхүүгийн ажилтнуудыг сургалтад хамруулах, дотоод хяналтыг сайжруулах, Төр засгийн амралт үйлчилгээний цогцолборын санхүүгийн тайланг ҮАГ-т аудит хийлгэхээр ирүүлж байх, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газарт төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу ашиглах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас харьяа байгууллагуудад албан бичиг хүргүүлж, ҮАГ-аас хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож, аудитын мөрөөр зохиох ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Зөвлөмжийн биелэлтийг гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2013 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн Х/334, 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Х/591, ТЗҮЭГ-ын 2013 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 519, 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 763 дугаар албан бичгээр тус тус ҮАГ-т ирүүлсэн байна.

Аудитын санал дүгнэлт

Бид Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж ҮАГ-САГ/2014/03/-СТА-ТЕЗ

Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна гэсэн “**зөрчилгүй**” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 674

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Тамгын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Тамгын газар-А4 бланк



Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1: Авлага

Асуудал 2: Дуусаагүй барилга

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг илрүүлэх боломжгүй юм.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Ерөнхий санхүүч Ж.Бямбасүрэн, санхүүгийн тайлангийн нэгтгэл хариуцсан референт Д.Цэцэгмаа, хөрөнгө оруулалт хариуцсан шинжээч Б.Ганбаатар нар болон санхүүгийн бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

ТЗҮЭГ-ын санхүүгийн тайланд 1999-2008 онд үүссэн нийт 42.8 сая төгрөгийн, Удирдлагын академид 19.2 сая, Монгол төрийн музейд 2007 онд үүссэн 6.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар дорвитой арга хэмжээ аваагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

ЗГХЭГ-т 2012 онд үүссэн Төрийн ёслол, хүндэтгэлийн өргөө цогцолборт дууны төхөөрөмж, дагалдах хэрэгслийн хамт нийлүүлэх 74.8 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр хаагдаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4. ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах; 8.4. Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд гарсан алдааг залруулахдаа холбогдох баримт материалыг үндэслэн зөв үзүүлэлтийг бичсэн нэмэлт баримт бүрдүүлэн, залруулга хийсэн болон зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна” гэж заасныг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Эрсдэлүүд

Авлага найдваргүй болох эрсдэл,
/Т, Э, Ү/

ҮАГ-ын зөвлөмж

Сайдын багцын хэмжээнд үүсээд 6-15 жил болсон 68.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах, хэрэв буруу бичилт хийгдсэн гэж үзвэл баримтаас хөөн шалгах замаар алдааг илрүүлж баримтжуулан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4-т заасны дагуу залруулах,

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган
танилцуулж, зөвшөөрүүлсэн.

ҮАГ-ын ажиглалт

Тус сайдын багцад батлагдан 2011-2013 онд баригдаж эхэлсэн Булган аймгийн ЗДТГ-ын барилгын санхүүжилтэд 2,291.1 сая төгрөг, Засгийн газрын авто баазын барилгын санхүүжилтэд 2,750.0 сая төгрөг, нийт 5,041.1 сая төгрөгийн санхүүжилтийн дүнгээр тухайн байгууллагуудын санхүүгийн тайланд “Дуусаагүй барилга” хэлбэрээр тусгагдаагүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд хөрөнгө, эх үүсвэр буруу илэрхийлэгдэх.
/Э, Ү, Т/

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана, 16.1. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдөнө зэрэг заалтыг мөрдөж тухайн байгууллагуудын санхүүгийн тайланд “Дуусаагүй барилга” дансанд тусгуулах арга хэмжээ авч ажиллах,

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшөөрүүлсэн.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /2013 он/

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
НИЙТ ДҮН	-	-
МӨНГӨН ХӨРӨНГӨ	444,140,555.91	400,219,448.76
Кассанд байгаа бэлэн мөнгө	46,295,115.30	69,229,190.00
Төгрөг\ ЖМС	30,084,535.03	44,779,457.54
Гадаад валют	16,210,580.27	24,449,732.46
Банкинд байгаа бэлэн мөнгө	397,845,440.61	330,990,258.76
Төгрөг	397,845,440.61	330,990,258.76
Төсөвт байгууллагын харилцах	40,303,940.00	20,001,214.00
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	357,541,500.61	234,368,990.43
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	76,620,054.33
АВЛАГА	1,584,158,760.01	1,784,185,795.50
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,883,445.39
Төлбөртэй үйлчилгээний авлага	169,065,566.10	212,895,031.46
Бусад авлага	1,415,093,193.91	1,569,407,318.65
Байгууллагаас авах авлага	1,404,560,795.91	1,555,982,657.64
Бусад зардлын тооцооны авлага	1,404,560,795.91	1,555,982,657.64
Хувь хүмүүсээс авах авлага	10,532,398.00	13,424,661.01
УРЬДЧИЛГАА	155,857,328.00	99,858,128.00
Бусад урьдчилгаа	155,857,328.00	99,858,128.00
БАРАА МАТЕРИАЛ	1,683,892,324.85	2,060,552,570.87
Түүхий эд материал	314,370,230.06	552,349,158.34
Тусгай зориулалттай материал	-	3,094,990.00
Дуусаагүй үйлдвэрлэл	60,935,047.00	60,935,047.00
Бэлэн бүтээгдэхүүн	253,435,183.06	488,319,121.34
Хангамжийн материал	1,362,723,194.79	1,502,293,412.53
Бичиг хэргийн материал	17,040,872.41	46,386,422.36
Аж ахуйн материал	343,301,545.38	345,111,135.81
Сэлбэг хэрэгсэл	72,902,995.65	69,829,707.22
Түлш, шатах тослох материал	1,907,304.99	27,245,235.13
Барилгын засварын материал	35,417,591.80	65,733,969.00
Хүнсний материал	382,882,551.63	489,342,088.72
Бусад бараа материал	509,270,332.93	458,644,854.29
Мал амьтад	6,720,000.00	5,910,000.00
Бусад	78,900.00	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,868,048,968.77	4,344,815,943.13
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	48,192,086,623.25	49,332,999,668.07
Биет хөрөнгө	48,078,118,774.74	49,248,983,644.33
Барилга, байгууламж, орон сууц	42,212,291,473.78	41,294,866,828.95
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	75,548,886,609.83	75,842,529,916.83
Барилга, байгууламж орон сууц – Хуримтлагдсан элэгдэл	(33,336,595,136.05)	(34,547,663,087.88)
Авто-тээврийн хэрэгсэл	3,185,154,583.12	3,861,911,643.46
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	7,093,846,254.00	7,692,640,836.00
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(3,908,691,670.88)	(3,830,729,192.54)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,132,007,626.71	1,937,209,226.54
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	2,968,245,873.10	3,785,457,735.33

Машин тоног төхөөрөмж(компьютер) – Хуримтлагдсан элэгдэл	(1,836,238,246.39)	(1,848,248,508.79)
Тавилга, аж ахуйн эд хогшил	788,723,167.78	910,482,083.29
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	2,563,736,871.68	2,670,280,178.43
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(1,775,013,703.90)	(1,759,798,095.14)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	249,850,862.00	620,857,022.85
Бусад үндсэн хөрөнгө	510,091,061.35	623,656,839.24
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	898,082,004.21	864,253,753.43
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(523,559,811.04)	(385,824,938.37)
Номын фонд	135,568,868.18	145,228,024.18
Биет бус хөрөнгө	113,967,848.51	84,016,023.74
Програм хангамж	91,488,326.06	67,642,306.85
Програм хангамж - Анхны өртөг	151,567,918.25	184,045,943.33
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(60,079,592.19)	(116,403,636.48)
Бусад биет бус хөрөнгө	22,479,522.45	16,373,716.89
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	38,665,747.49	38,665,747.49
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(16,186,225.04)	(22,292,030.60)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	52,060,135,592.02	53,677,815,611.20
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,633,784,502.71	1,456,292,716.03
Өглөг	95,538,037.91	112,189,221.55
Ажилчидтай холбогдсон тооцоо	1,150,187.00	2,305,168.00
НДШ-ийн өглөг	250,304.00	-
ХАОАТ-ын өглөг	899,883.00	2,305,168.00
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	73,214,106.02	11,494,036.24
Тээвэр шатахуунын тооцоо	52,875,398.40	1,801,610.03
Бусад зардлын тооцоо	20,338,707.62	9,692,426.21
Бусад өглөг	21,173,744.89	98,390,017.31
Байгууллагад төлөх өглөг	21,173,744.89	98,390,017.31
Урьдчилж орсон орлого	1,538,246,464.80	1,344,103,494.48
Төсөвт байгууллага	1,537,043,424.80	88,952,389.37
Урьдчилж орсон орлого	1,537,043,424.80	88,952,389.37
Бусад урьдчилж орсон орлого	1,203,040.00	1,255,151,105.11
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,633,784,502.71	1,456,292,716.03
Засгийн газрын хувь оролцоо	50,426,351,089.31	52,221,522,895.17
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	26,446,168,132.16	29,157,252,970.96
Хуримтлагдсан үр дүн	5,138,415,244.02	4,218,225,911.08
Өмнөх үеийн үр дүн	5,138,415,244.02	4,789,008,492.57
Тайлант үеийн үр дүн	-	(570,782,581.49)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,841,767,713.13	18,846,044,013.13
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	50,426,351,089.31	52,221,522,895.17
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	52,060,135,592.02	53,677,815,611.20

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН 2013 он

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
НИЙТ ДҮН	-	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,459,007,779.81	25,210,467,676.12
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	39,459,007,779.81	25,210,467,676.12
Улсын төвлөрсөн төсвөөс	33,624,742,138.81	25,199,966,416.12
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,919,341,991.81	12,850,053,820.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	1,029,700,000.00	-
Хөрөнгийн	18,675,700,147.00	11,158,219,848.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,151,889,793.62
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	37,100,000.00
Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ	-	62,352,997.62
хоорондын гэрээ болон ОУбайгуулл		
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах	-	899,750,000.00
ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс		
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	-	151,854,196.00
төсвөөс доод шатны төсвийн захи		
Төсвийн урамшуулал	-	832,600.00
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	-	39,802,954.50
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн	5,423,838,506.00	-
дэмжлэг		
Хөрөнгийн	5,423,838,506.00	-
Нийгмийн даатгалын сангаас	14,801,395.00	383,060.00
НДС-ийн шилжүүлэг	14,801,395.00	383,060.00
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас	395,625,740.00	10,118,200.00
санхүүжих		
Төрийн сургалтын санд олгох	395,625,740.00	10,118,200.00
Буцалтгүй тусламжаар суралцагчдын тэтгэлэг	395,625,740.00	10,118,200.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,462,077,285.24	8,714,508,647.00
Өмчийн орлого	272,484,072.10	340,766,236.36
Түрээсийн орлого	272,484,072.10	340,766,236.36
Төрийн өмч түрээслүүлсний орлого	272,484,072.10	340,766,236.36
Бараа, үйлчилгээний борлуулалт	4,189,593,213.14	8,373,742,410.64
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	4,189,593,213.14	8,373,742,410.64
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,423,872,666.46	6,999,711,952.44
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	518,242,358.13	1,334,669,658.20
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	246,285,328.75	39,027,800.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,192,859.80	333,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	43,921,085,065.05	33,924,976,323.12
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	8,400,647,491.72	10,284,593,907.20
Үндсэн болон нэмэгдэл цалин	7,531,729,607.72	9,210,860,066.55

Үндсэн цалин	7,386,275,436.72	9,021,034,562.75
Гэрээт ажилчдын цалин	8,212,904.00	107,881,403.80
Унаа хоолны хөнгөлөлт	79,946,926.00	2,631,400.00
Бусад нэмэгдлүүд	57,294,341.00	79,312,700.00
Унаа, болон бусад нөхөн олговор	57,294,341.00	79,312,700.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	868,917,884.00	1,073,733,840.65
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	796,920,782.22	978,452,652.26
Тэтгэврийн даатгалын шимтгэл	724,821,556.49	930,382,977.72
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	17,938,340.35	12,276,366.86
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	36,229,442.03	24,236,657.82
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	17,931,443.35	11,556,649.86
Эрүүл мэндийн даатгалын хураамж	71,997,101.78	95,281,188.39
УРСГАЛ ЗАРДАЛ	12,997,188,942.60	13,561,818,430.49
Бараа үйлчилгээний урсгал зардал	9,300,127,305.22	10,379,861,226.51
Тогтмол зардал	1,196,672,993.11	1,287,543,196.24
Гэрэл цахилгаан	504,682,131.00	568,332,172.00
Түлш, халаалт	595,430,075.07	635,783,968.06
Цэвэр, бохир ус	96,560,787.04	83,427,056.18
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	187,458.93	3,376,853.52
Хоол	-	2,974,700.00
Эм, вакцин	187,458.93	402,153.52
Бусад бараа үйлчилгээний зардал	8,103,266,853.18	9,088,941,176.75
Бичиг хэргийн зардал	115,161,227.36	128,111,629.03
Тээвэр, шатахуун	446,715,773.00	426,995,581.00
Шуудан, харилцаа холбоо	147,195,356.43	192,191,055.60
Дотоод албан томилолт	101,093,821.80	203,195,212.99
